



НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 10 сарын 18 өдөр

Дугаар А/60

Улаанбаатар хот

Нийтийн биеийн тамир, спортын онол практикийн хурал зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргааны, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Биеийн тамир, спортын тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2015 оны 144 дүгээр зарлиг, Засгийн газрын 2009 оны 05, 2014 оны 34 дүгээр тогтоолууд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Нийтийн биеийн тамир, спортын онол практикийн хурлыг 2017 оны 11 дүгээр сарын 29-ны өдөр Засгийн газрын XI байрны хурлын зааланд зохион байгуулсугай.

2. Нийтийн биеийн тамир, спортын Онол практикийн хурлыг зохион байгуулахад шаардагдах төсвийг нэгдүгээр, шүүгчдийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Онол практикийн хурлыг зохион байгуулахад шаардагдах 1.450.000 /Нэг сая дөрвөн зуун тавин мянган/ төгрөгийг Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны биеийн тамир, чийрэгжүүлэлтийн нийтийг хамарсан арга хэмжээний зардлаас гаргахыг нягтлан бодогч /О.Эрдэнэцэцэг/-д зөвшөөрсүгэй.


4. Тэмцээний урьдчилсан бэлтгэлийг сайтар хангаж, зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулахыг Нийтийн биеийн тамирын хөгжлийн хэлтсийн дарга /А.Болдмаа/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБОЛД

Нийслэлийн Нийтийн Биеийн тамир, спортын хорооны
даргын 2017 оны *10.24.2017* сарын *18*-ны өдрийн
А.Болдмаа дугаар тушаалын нэгдүгээр хавсралт




Нийтийн биеийн тамир, спортын онол практикийн
хурлыг зохион байгуулах төсөв

№	Зардлын нэр	Нийт дүн /төг/
1.	Хуралд оролцогчдын шагнал: 2 x 100.000=200.000 төг 2 x 80.000=160.000 төг 2 x 60.000=120.000 төг	480.000
2.	Багийн шагнал	300.000
3.	Багшийн ажлын мөнгө: 5 шүүгч x 1 хоног 30.000 төг	150.000
4.	Заал талбайн зардал	300.000
5.	Анонс, урилга	120.000
6.	Цом, өргөмжлөл	100.000
ДҮН:		1.450.000

Боловсруулсан
Хянасан

А.Болдмаа
О.Эрдэнэцэцэг

Нийслэлийн Нийтийн Биеийн тамир, спортын хорооны даргын 2017 оны *10* сарын *18*-ны өдрийн *160* дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



Нийтийн биеийн тамир, спортын онол практикийн хурлыг шүүгчдийн бүрэлдэхүүн

- | | |
|-----------------|---|
| 1. А.Болдмаа | ННБТСХороо Нийтийн биеийн тамирын хөгжлийн хэлтсийн Дарга |
| 2. Л.Алтанцэцэг | Үндэсний Биеийн тамирын дээд сургуулийн захирал |
| 3. Л.Туяа | МУБИС-ийн багш |
| 4. Ш.Долгор | ЗГХА Биеийн тамир, спортын газрын мэргэжилтэн |
| 5. Ц.Ганбаатар | СБД-ийн БТСДС-ийн багш |